“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ

“СЭКЮР ФИНАНС ББСБ”

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

2022 оны 12 сарын 31-ний өдрөөр

дуусгавар болсон жилийн

санхүүгийн тайлан

Улаанбаатар хот, 2022 он

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

(Монгол улсад бүртгэлтэй компани)

Аудитлагдсан санхүүгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

КОМПАНИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ	: Т.Тэгшжаргал
АЛБАН ЁСНЫ ХАЯГ	: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо, 7-р хороолол, Ногоон нуур, 25, Прован оффис 309 тоот Утас:75778085
ХАРИЛЦАГЧ БАНК	: Тээвэр Хөгжлийн Банк, Хаан банк, Төрийн банк, Голомт банк
Аудиторууд	:СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК
	Мэргэшсэн нягтлан бодогчид

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК (цаашид компани гэнэ)-ийн гүйцэтгэх захирал Т.Тэгшжаргал би энэхүү хавсралтад үзүүлсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээг санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг батламжилж байна.

Т.Тэгшжаргал

Улаанбаатар хот, монгол улс

Огноо: 2023.01.11

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

СРТА
AUDIT LLC
“СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ”ХХК

БАТАЛГААЖУУЛАЛТ, АУДИТ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ЗӨВЛӨГӨӨ

Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот
Улаанбаатар хот, Монгол улс, 16010, Утас: 11-976-99046494

Огноо:2022.01.09 № Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид 2022 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК компанийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК компанийн 2022 оны 12 сарын 31-нээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулж (эсвэл эдгээрийн талаар үнэн бөгөөд зөв ойлгоц өгч) байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн Тайлангийн Аудитад хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд хамаарах ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд хүлээх Үүрэг Хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэсээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээх Аудиторын хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм. Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Тэдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагад нийцэж ажиллах мөн санхүүгийн тайлангууд нь материалллаг алдаагүй эсэх талаар зохимжтой баталгаажуулалтыг олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Сонгон авах горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторуудын мэргэжлийн үнэлэмжээс хамаарна. Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзаж үздэг.

Мөн аудитын ажилд хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлж үзэх ажил орно.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хэрэглээний хязгаарлалт

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалсан аудиттай холбогдуулан Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулж гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогч

Гүйцэтгэх захирал Ч.ЭНХЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот **Утас: 976 – 9904 6494; 86030388**
Баянзүрх дүүрэг, 3-р хороо, Оршил төв 501 тоот

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31	Тэмдэглэл	21.12.31	22.12.31
ХӨРӨНГӨ			
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгөн хөрөнгө	4	473,766,766.54	416,320,693.22
Банк санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах		473,766,766.54	416,320,693.22
Нийт зээл /цэврээр/	5	5,992,048,036.62	7,384,139,131.58
Нийт зээл		6,185,005,055.00	7,532,002,328.35
Бусад хөрөнгө	6	9,831,678.94	11,705,572.58
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	7	171,017,633.68	160,634,334.57
Эргэлтийн хөрөнгийн дүн		**6,646,664,115.78**	**7,972,799,731.95**
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө		58,401,291.86	42,443,779.10
Биет бус хөрөнгө		19,286,089.00	85,249,999.66
Үндсэн хөрөнгийн дүн		**77,687,380.86**	**127,693,778.76**
Нийт хөрөнгө		**6,724,351,496.64**	**8,100,493,510.71**
ӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Өрийн бичгээрх өглөг	8	1,200,000,000.00	1,325,000,000.00
Татварын өр	9	87,614,041.01	99,357,931.66
Бусад өглөг	10	307,100.00	16,259,056.82
Өр төлбөрийн дүн		**1,287,921,141.01**	**1,440,616,988.48**
ЭЗДИЙН ӨМЧ			
Хувийн өмч	11	2,650,000,000.00	5,152,000,000.00
Хуримтлагдсан ашиг		2,786,430,355.63	1,507,876,522.23
Эздийн өмчийн дүн		**5,436,430,355.63**	**6,659,876,522.23**
Нийт эздийн өмч ба өр төлбөр		**6,724,351,496.64**	**8,100,493,510.71**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2022 ОНЫ 12 САРЫН 31

Үзүүлэлт	Тэмдэглэл	21.12.31	22.12.31
Хүүгийн орлого	12	1,852,431,940.84	2,602,625,965.27
Хүүгийн зардал	13	37,690,091.76	154,754,630.14
Хүүгийн бус орлого	14	61,922,818.64	70,201,616.26
Хүүгийн бус зардал	15	581,031,041.03	690,990,328.62
Цэвэр хүүгийн бус орлого/зардлын дүн		**(519,108,222.39)**	**(620,788,712.36)**
Болзошгүй эрсдэлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал		**1,295,633,626.69**	**1,827,082,622.77**
Болзошгүй эрсдэлийн зардал	16	66,935,146.32	166,241,602.33
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал		**1,228,698,480.37**	**1,660,841,020.44**
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	17	-	69,074,148.58
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	18	14,724,091.00	57,516,746.57
Ердийн үйл ажиллагааны өмнөх ашиг/алдагдал		**1,213,974,389.37**	**1,672,398,422.45**
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал		**1,213,974,389.37**	**1,672,398,422.45**
Орлогын татварын зардал	19	122,869,913.31	170,952,255.85
Татварын дараах ашиг		**1,091,104,476.06**	**1,501,446,166.60**
Цэвэр ашиг		**1,091,104,476.06**	**1,501,446,166.60**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Эздийн өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт
2021 оны 12 сарын 31 үлдэгдэл	**2,650,000,000.00**	**2,786,430,355.63**	**5,436,430,355.63**
Залруулсан үлдэгдэл	2,650,000,000.00	6,430,355.63	2,656,430,355.63
Өмчид гарсан өөрчлөлт	2,502,000,000.00		**2,502,000,000.00**
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	1,501,446,166.60	1,501,446,166.60
2022 оны 12 сарын 31 үлдэгдэл	**5,152,000,000.00**	**1,507,876,522.23**	**6,659,876,522.23**

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

“СЭКЮР ФИНАНС ББСБ” ХХК

2022 оны 12 сарын 31-ны санхүүгийн тайлан

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	22.12.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
Мөнгөн орлогын дүн	**2,672,827,567.53**
Зээлийн хүүгийн орлого	2,602,655,294.20
Гадаад валютын ханшийн зөрүү	17,152.57
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	70,184,449.69
Хүүгийн орлогын буцаалт	(29,328.93)
Мөнгөн зарлагын дүн	**2,689,161,485.31**
Өрийн бичгийн хүү	154,754,630.14
Үндсэн ба нэмэгдэл цалин	349,571,306.13
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	4,175,438.00
Нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн	49,223,467.64
Албан томилолт сургалтын зардал	17,121,757.00
Ашиглалтын зардалд төлсөн	6,508,116.50
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	27,932,475.06
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	14,674,755.14
Татварын байгууллагад төлсөн	170,952,255.85
Зар сурталчилгаанд төлсөн	21,238,496.14
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой гарсан мөнгө	350,971.88
Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаатай холбогдон гарсан мөнгө	74,276,000.00
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	5,400,000.00
Зохицуулалтын үйлчилгээний хураамжинд төлсөн мөнгө	3,240,000.00
Бусад мөнгөн зарлага	1,789,741,815.83
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	**(16,333,917.78)**
Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
Мөнгөн орлогын дүн	**1,472,695.00**
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	1,472,695.00
Мөнгөн зарлагын дүн	**42,584,850.54**
Баяр ёслол, зочин төлөөлөгчийн зардал	20,545,310.54
Бусад	22,039,540.00
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн дүн	**(41,112,155.54)**
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	
Мөнгөн орлогын дүн	-
Мөнгөн зарлагын дүн	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	**(57,446,073.32)**
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	473,766,766.54
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	**416,320,693.22**